



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
192 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, 59.10 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 3.2, 7.16, 7.19.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 11:00 цагт Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн байрны 4 давхрын хурлын зааланд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсүгэй. Үүнд:

2.1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай;

- Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
- Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа нэмж гаргах тухай, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай;
- Олон нийтэд нээлттэй санал болгох хувьцааны тоо ширхгийг тогтоох тухай;
- Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;
- Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай;
- Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахыг тогтоох тухай;
- Компанийн одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх буюу тусгаарлуулах үүрэг хүлээх тухай;
- Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах тухай;
- Хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;

- Нэмж гаргасан хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрсөн хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг танилцуулах тухай;
- 2.2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай;
- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр байхаар тогтсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хоёроос доошгүй өдөр тутмын сонин, телевиз, компанийн болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, зарыг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг 1 дүгээр хавсралтаар, танилцах баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төв байранд болон цахим хэлбэр /www.telecommongolia.mn/-ээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Цэцэгмаа/-д даалгасугай.
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ын загварыг 3 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-ыг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 10:30 цаг байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар С.Нямбаярыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын даргаар С.Цог, гишүүдээр Б.Хулан, Т.Бямбасүрэн нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар Ч.Цогтгэрэл, гишүүдээр Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Ч.Цогтгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЛХАГВАСҮРЭН

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ**

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	11:00-11:30
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хэлэлцүүлэх	60 минут
	1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай; 2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай; 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай	
5.	Асуулт хариулт, санал	30 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай;
 - 1.1. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
 - 1.2. Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа нэмж гаргах тухай, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай баримт материал;
 - 1.3. Олон нийтэд нээлттэй санал болгох хувьцааны тоо ширхгийг тогтоох тухай баримт материал;
 - 1.4. Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай баримт материал;
 - 1.5. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай баримт материал;
 - 1.6. Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахыг тогтоох тухай баримт материал;
 - 1.7. Компанийн одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх буюу тусгаарлуулах үүрэг хүлээх тухай баримт материал;
 - 1.8. Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах тухай баримт материал;
 - 1.9. Хувьцаа нэмж гаргах, хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргахтай холбоотой бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай баримт материал;
 - 1.10 Нэмж гаргасан хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрсөн хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг танилцуулах тухай баримт материал;
2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай баримт материал;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай баримт материал

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерын овог нэр

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 11:00 цагт Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн байрны 4 давхрын хурлын зааланд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
1.	Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай;				
2.	2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай;				
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай;				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр:	ХЭ хуулийн этгээдийн нэр:
Гарын үсэг:	Улсын бүртгэлийн дугаар.....
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал:.....
	Гарын үсэг:
Регистрийн дугаар:	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	